



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Гурванзагал сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/22/СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
Чойбалсан хот	бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
2021 он	Утас: 7058-4203      Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
	Аудитын менежер:      И.Сэмжидмаа
	Утас: 7058-4207      Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Аудитор:      Э.Нандинчимэг
	Утас: 7000-3775      Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ДОА	Дорнод аймаг
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд



## Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	9
3.4. Материаллаг байдал .....	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	10
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.9. Аудитын илрүүлэлт.....	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	11
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	12
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	13

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 296

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г \_\_\_\_\_ Т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Гурванзагал сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Гурванзагал сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Гурванзагал сумын цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 95 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020274

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын рүүдэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,223,352.20</b>	<b>25,074,034.70</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	15,223,352.20	25,074,034.70
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,223,352.20	25,074,034.70
35410	Бичиг хэргийн материал	334,000.00	334,000.00
35420	Аж ахуйн материал	13,701,452.20	20,040,024.70
35450	Барилгын засварын материал	-	4,700,010.00
35460	Хүнсний материал	1,187,900.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>294,167,437.15</b>	<b>368,565,824.32</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	294,167,437.15	368,565,824.32
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	281,160,828.84	355,559,216.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	230,320,044.88	313,485,289.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,986,092.60)	(12,691,879.17)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,683,060.00	24,383,695.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,424,510.16)	(10,831,428.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,203,632.00	11,776,589.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,245,275.15)	(6,604,835.51)
39209	Зам, гүүрийн байгууламж	21,198,692.80	21,198,692.80
39210	Хуримтлагдсан элэгдэл	(8,574,775.56)	(9,934,716.09)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	311,495.00	311,495.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	39,892,391.00	39,892,391.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,217,833.37)	(15,426,078.20)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,006,608.31	13,006,608.31
39303	Бусад биет бус хөрөнгө	13,018,800.00	13,018,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(12,191.69)	(12,191.69)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>309,390,789.35</b>	<b>393,639,859.02</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>309,390,789.35</b>	<b>393,639,859.02</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	309,390,789.35	393,639,859.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	81,837,576.00	81,837,576.00
51101	Өмч - төрийн	81,837,576.00	81,837,576.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	98,124,716.23	182,373,785.90
51210	Өмнөх үеийн үр дүн	98,124,716.23	98,124,716.61
51220	Тайлант үеийн үр дүн	-	84,249,069.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	129,428,497.12	129,428,497.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>	<b>309,390,789.35</b>	<b>393,639,859.02</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (0)	359,230,342.00	302,772,810.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	279,545,029.00	277,724,810.00
120	Нийтлэг татварын бус орлого	134,424,029.00	91,367,410.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	134,424,029.00	91,367,410.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	134,424,029.00	91,367,410.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	145,121,000.00	186,357,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	145,121,000.00	186,357,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,685,313.00	25,048,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,685,313.00	25,048,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,685,313.00	25,048,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	238,638,461.35	218,523,740.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,638,461.35	218,523,740.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,138,461.35	210,790,979.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,817,424.00	138,474,779.00
210101	Үндсэн цалин	87,886,024.00	97,501,865.25
210102	Нэмэгдэл	8,405,600.00	28,786,195.75
210104	Урамшуулал	9,525,800.00	12,186,718.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,399,400.00	17,357,100.00
210201	Тэтгэврийн даатгал	9,198,300.00	11,802,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	985,200.00	1,388,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	857,700.00	1,110,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	214,500.00	277,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,143,700.00	2,777,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,377,376.00	17,409,208.00
210301	Гэрэл, пахилгаан	1,975,188.00	2,731,040.00
210302	Түлш, халаалт	17,602,188.00	13,487,168.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	1,191,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,991,800.00	3,946,051.00
210401	Бичиг хэрэг	333,000.00	459,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,183,900.00	1,098,901.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,174,900.00	2,087,250.00
2105	Нормативт зардал	18,118,500.00	14,445,391.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	170,000.00	308,000.00
210502	Хоол, хүнс	17,773,500.00	14,067,839.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	175,000.00	69,552.00
2107	Томилолт, зочны зардал	292,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	292,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,946,113.00	270,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,946,113.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,195,848.35	18,388,450.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	642,800.00	348,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	15,553,048.35	18,040,450.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	7,732,761.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	1,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,100,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6,632,761.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,632,761.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	120,591,880.65	84,249,069.29
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	120,591,880.65	84,249,069.29

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>224,806,313.00</b>	<b>211,405,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>145,121,000.00</b>	<b>186,357,400.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	145,121,000.00	186,357,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	145,121,000.00	186,357,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>79,685,313.00</b>	<b>25,048,000.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	79,685,313.00	25,048,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,685,313.00	25,048,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>224,806,313.00</b>	<b>211,405,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>224,806,313.00</b>	<b>211,405,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>224,306,313.00</b>	<b>203,672,639.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	107,194,800.00	138,474,779.00
210101	Үндсэн цалин	89,263,400.00	97,501,865.25
210102	Нэмэгдэл	8,405,600.00	28,786,195.75
210104	Урамшуулал	9,525,800.00	12,186,718.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,399,400.00	17,357,100.00
210201	Тэтгэврийн даатгал	9,198,300.00	11,802,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	985,200.00	1,388,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	857,700.00	1,110,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	214,500.00	277,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,143,700.00	2,777,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,000,000.00	17,309,208.00
210301	Гэрэл, пахилгаан	1,975,188.00	2,731,040.00
210302	Түлш, халаалт	16,224,812.00	13,387,168.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	1,191,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,925,400.00	4,014,061.00
210401	Бичиг хэрэг	300,600.00	547,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,183,900.00	1,198,901.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,040,900.00	1,847,260.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,641,400.00	16,591,491.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,000.00	220,000.00
210502	Хоол, хүнс	18,961,400.00	12,879,939.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	3,491,552.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,000,000.00	7,075,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	7,075,000.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	292,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилголт	292,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	58,953,313.00	270,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	58,953,313.00	270,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	900,000.00	2,081,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	2,081,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>500,000.00</b>	<b>7,732,761.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	1,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,100,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	6,632,761.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,632,761.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	81,837,576.00	129,428,497.12	98,124,716.23	0.00	309,390,789.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>81,837,576.00</b>	<b>129,428,497.12</b>	<b>98,124,716.23</b>	<b>0.00</b>	<b>309,390,789.35</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>81,837,576.00</b>	<b>129,428,497.12</b>	<b>98,124,716.23</b>	<b>0.00</b>	<b>309,390,789.35</b>
<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>81,837,576.00</b>	<b>129,428,497.12</b>	<b>98,124,716.23</b>	<b>0.00</b>	<b>309,390,789.35</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.38	0.00	0.38
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>81,837,576.00</b>	<b>129,428,497.12</b>	<b>98,124,716.61</b>	<b>0.00</b>	<b>309,390,789.73</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	84,249,069.29	0.00	84,249,069.29
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>81,837,576.00</b>	<b>129,428,497.12</b>	<b>182,373,785.90</b>	<b>0.00</b>	<b>393,639,859.02</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	166,121,000.00	166,121,000.00	213,448,300.00	204,772,639.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	166,121,000.00	166,121,000.00	213,448,300.00	204,772,639.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	165,621,000.00	165,621,000.00	212,348,300.00	203,672,639.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	107,194,800.00	107,194,800.00	138,862,300.00	138,474,779.00
210101	Үндсэн цалин	89,263,400.00	89,263,400.00	107,034,400.00	97,501,865.25
210102	Нэмэгдэл	8,405,600.00	8,405,600.00	22,479,100.00	28,786,195.75
210104	Урамшуулал	9,525,800.00	9,525,800.00	9,348,800.00	12,186,718.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,399,400.00	13,399,400.00	17,357,100.00	17,357,100.00
210201	Тэтгэврийн даатгал	9,111,300.00	9,198,300.00	11,802,700.00	11,802,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,072,200.00	985,200.00	1,388,600.00	1,388,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	857,700.00	857,700.00	1,110,900.00	1,110,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	214,500.00	214,500.00	277,700.00	277,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,143,700.00	2,143,700.00	2,777,200.00	2,777,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,000,000.00	19,000,000.00	17,548,000.00	17,309,208.00
210301	Гэрэл, цахилгаан	1,550,000.00	1,975,188.00	2,900,000.00	2,731,040.00
210302	Түлш, халаалт	16,650,000.00	16,224,812.00	13,448,000.00	13,387,168.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00	1,200,000.00	1,191,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,925,400.00	2,925,400.00	6,462,000.00	4,014,061.00
210401	Бичиг хэрэг	300,600.00	300,600.00	600,000.00	547,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,183,900.00	1,183,900.00	1,200,000.00	1,198,901.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00	300,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00	162,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,040,900.00	1,040,900.00	4,200,000.00	1,847,260.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,641,400.00	19,641,400.00	19,800,700.00	16,591,491.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,000.00	80,000.00	220,000.00	220,000.00
210502	Хоол, хүнс	18,961,400.00	18,961,400.00	16,080,700.00	12,879,939.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00	3,500,000.00	3,491,552.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,000,000.00	2,000,000.00	7,800,000.00	7,075,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	7,800,000.00	7,075,000.00
<b>2107</b>	<b>Төмилөлт, зочны зардал</b>	292,000.00	292,000.00	1,000,000.00	500,000.00
210702	Дотоод албан төмилөлт	292,000.00	292,000.00	1,000,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	268,000.00	268,000.00	270,000.00	270,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	268,000.00	268,000.00	270,000.00	270,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	900,000.00	900,000.00	3,248,200.00	2,081,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	900,000.00	3,248,200.00	2,081,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	500,000.00	500,000.00	1,100,000.00	1,100,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	500,000.00	1,100,000.00	1,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	1,100,000.00	1,100,000.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	166,121,000.00	166,121,000.00	213,448,300.00	211,405,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	166,121,000.00	166,121,000.00	213,448,300.00	211,405,400.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ч.Жаргалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Гурванзагал сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Гурванзагал сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль бусад холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаалын шийдвэрийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Гурванзагал сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Гурванзагал сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 218,524.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 4,370.4 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гурванзагал сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,249.7 мянган төгрөгөөр буюу 30.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	15,223.3	25,074.0	9,850.7
Үндсэн хөрөнгө	331,628.1	424,066.9	92,438.8
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(37,460.7)	(55,501.1)	(18,040.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>309,390.7</b>	<b>393,639.8</b>	<b>84,249.1</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	81,837.5	81,837.5	
Хуримтлагдсан үр дүн	98,124.7	182,373.8	84,249.1-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>183,431.49</b>	<b>229,972.55</b>	<b>84,249.1</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 25,074.0 мянган төгрөг болж 9,850.7 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 424,066.9 мянган төгрөг болж 92,438.8 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 92,438.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Гурванзагал сумын цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 302,772.8 мянган төгрөгөөр буюу 15.7 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 218,523.7 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ковид 19-тэй холбоотойгоор хоол хүнс, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд буурсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 213,448.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 213,448.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 213,448.3 мянган төгрөгөөр баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 213,448.3 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 211,405.4 мянган төгрөгийн санхүүжилт орлого авч, урсгал үйл ажиллагаанд 204,772.6 мянган төгрөгийг зарцуулж 6,632.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 204,772.6 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 155,831.9 мянган төгрөг буюу нийт зардлын 76.1 хувийг эзэлж байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 144 мэдээлэл оруулснаас хугацаандаа оруулсан 107 мэдээлэл, хугацаа хоцорч 37 мэдээлэл оруулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Дараа жилийн төсвийн төслийн 108,376.3 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлэн ажиллаж, 1 төлбөрийн актыг хугацаандаа барагдуулсан.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 48,711.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 48,711.8 мянган төгрөгийн зөрчилд 1,098.9 мянган төгрөгийн акт тогтоож, 47,612.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 48,711.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 48,711.8 мянган төгрөгийн зөрчилд 1,098.9 мянган төгрөгийн акт тогтоож, 47,612.9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 1,098.9 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй зарцуулалт байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Худалдан авалтын үнийн гэрээний үнэ болон тендерийн үнийн саналтай харьцуулахад 11,692.0 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлсийн 2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил,



үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны эцэст 29,926.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогыг хангалтгүй чанаргүй хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийг НДШ-ийн тайлан, ХХОАТ-ын тайлантай тулгахад цалингийн дэлгэрэнгүй бүртгэл үр дүнгийн тайлан дахь дүнгээс 474.8 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “...нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална” үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Тайлант хугацаанд гарсан зардлаас 5,519.3 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.



## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.02.25</b>	Аудитын нэр: <b>Дорнод аймгийн Гурванзагал сумын Цэцэрлэг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>ДОА-2021/22/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Дорнод аймгийн Гурванзагал сумын Цэцэрлэг</b>	Мянган төгрөг: <b>Мянган төгрөг</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн тооллого хийсэн баримтаас үзэхэд данс дансаар нь тулгаж товчоо хийсэн дүн байхгүй тулгалт хийхэд ойлгомжгүй шаардлага хангахгүй чанаргүй байна. Газар. санхүүгийн программыг нэг дансанд хольж бүртгэсэн. Номыг 39217 тоот дансанд бүртгэхийг 39211 Батлан хамгаалах цэргийн тоног төхөөрөмж гэсэн дансанд бүртгэж тайланд буруу илэрхийлсэн. ҮХ-ийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тооллогын бүртгэлийг тулгахад 13,018.8 мянган төгрөгийн зөрүүтэй, БМ-ын тооллогын баримт 16,908.0 мянган төгрөгөөр дутуу тоологдсон байна.	29,926.8	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Ч.Жаргалмаа Ч.Болор-Эрдэнэ
2	Нийт 107 мэдээллийг хугацаанд нь оруулж 37 мэдээллийг хугацаа хоцорч оруулсан байна. Үүнд: 1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр) 2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр) 1, 4, 5, 9, 10, 11, 12 саруудад 3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) 5, 10 саруудад 4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) 5, 10 саруудад 5. Санхүүгийн тайлан (Хагас жилээр) Мөнгөн дүн 108,376.3 мян төгрөг 6. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр) 7. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр) 8. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Сар бүр) 9. Хөрөнгийн болон	0.0	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Ч.Жаргалмаа Ч.Болор-Эрдэнэ



	урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) 5 10 саруудад 10. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 5 10 саруудад 11. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) 5 10 саруудад 12. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 5 10 саруудад 13. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) 5 10 саруудад 14. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр) 5,10,12 саруудад 15. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр) 5 10 саруудад				
3	Хүнсний бүтээгдэхүүнийг Ольхон ХХК 5,143.1 мянган төгрөг, Лүнгийн хишиг ХХК 399.9 мянган төгрөг, Гантигчулуун ногоолин ХХК 727.4 мянган төгрөг, Дорнод гурил ХХК 546.5 мянган төгрөгийн худалдан авалтуудыг хийсэн боловч аль байгууллага дээр худалдан авалтын гэрээ байгуулаагүй байна.	11,692.0	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Ч.Жаргалмаа Ч.Болор-Эрдэнэ
4	Тайлант хугацаанд цахим төлбөрийн баримтад 5,519.3 мянган төгрөгийн и-баримт шивэгдээгүй байна.	5,519.3	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Ч.Жаргалмаа Ч.Болор-Эрдэнэ
5	Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийг НДШ-ийн тайлан, ХХОАТ-ын тайлантай тулгалтуудыг хийхэд 5, 7, 10, 12 саруудад НДШ тайлан дахь дүн СҮДТ дахь дүнтэй 474.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	474.8	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Ч.Жаргалмаа Ч.Болор-Эрдэнэ
6	Батлагдсан төсөв 1,200.0 мянган төгрөг бөгөөд СҮДТ буюу гүйцэтгэлээр зарцуулсан дүн нь 1,098.9 мянган төгрөг байна. Тухайн зарцуулсан шатахууны хэтрэлт хэмнэлтийг ЗТХСайлын 2019 оны 390 дугаар тушаалын дагуу жишиг нормыг тооцоход үндэслэл болгох АШБ үйлдээгүй/жолоочийн тооцооны хуудас/ байна	1,098.9	Төлбөрийн акт тогтоох	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Ч.Жаргалмаа Ч.Болор-Эрдэнэ
<b>ДҮН</b>		<b>48,711.8</b>			